

**“ТӨРИЙН ӨМЧӨӨС ОРОН НУТГИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ
ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь дараах зорилгоор тогтоолын төслийг боловсруулж, өргөн мэдүүлсэн байна. Үүнд:

-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан тус газрын эзэмшилд байсан төрийн өмчийн эд хөрөнгийг аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газарт шилжүүлэх,

-Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцдаг байгууллагууд аймаг, нийслэлийн өмчид шилжсэнтэй холбогдуулан шинээр баригдсан болон хуучин ашиглаж байсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үйлчилгээ, арчилгаа цэвэрлэгээ, зохицуулалт, хэрэглээнээс хамаарч орон нутгийн өмчид байлгах,

-Нийтийн эзэмшилд зориулан улсын төсөв, төрийн өмчит компаниас санхүүжүүлэн барьсан хөрөнгийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит байгууллага хариуцах,

-Нийгмийн эрүүл мэндийн түргэн тусламж, үйлчилгээ, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагад эд хөрөнгө шилжүүлэх,

-Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн автомашинуудыг алслагдсан сумдын цагдаагийн, эрүүл мэндийн байгууллагууд болон хот тохижилт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчийн байгууллагад шилжүүлэх.

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж төсөл санаачлагч үзсэн бөгөөд тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэхэд ямар зарчмыг баримтлан хуваарилсан талаар болон аймгийн төвөөс алслагдсан сум, багт дахин автомашин хуваарилах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр төрийн өмчит компаниудын менежмент, засаглалыг сайжруулах бодлогын асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэж, тавилга, эд хөрөнгийг орон нутагт шилжүүлэх асуудлыг Засгийн газар, агентлагийн түвшинд шийддэг болох талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг орон нутгийн өмчид шилжүүлж байгаа автомашинуудыг эхний ээлжинд эрүүл мэндийн газруудад хуваарилах боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ